

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Эрхтийн Цэрэнпил	Дугаар	L059
Оршин суугаа аймаг	Дорнод	Оршин суугаа сум	Дашбалбар сум
Төрсөн газар	Дорнод аймаг Дашбалбар сум	Төрсөн он	1924
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Дорлигийн дуган	Сүм хийдийн дугаар	ДОДБ 031
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 6	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Дорнод аймгийн Дашбалбар сумын Дорлигийн дуган

- Дашбалбар сумд ямар ямар сүм хийд байсан бэ?

Гуулинтын дуган гэж байсан. Хундаамны чулуу нь байгаа. Дөчийн зүүн биед байдаг.

-Харзын хошуугаар гараад л Дөчийн зүүн биеэр ороход байх уу?

Тэгнэ. Чулуун хороотын зүүнтээ нэг чулуун овоо байдаг. Тэнд дацан байсан л гэдэг. Чухам ямар нэртэй дацан байсныг нь мэдэхгүй байна. Дацан байсан гэсэн. Баахан чулуу байдаг. Бага далайн зүүнтээ дацан байсан гэдэг. Бага далай, их далай гэж байдаг штээ. Тэнд ямаан шүтээнтэй дацан байсан гэдэг. Ямаа майлдаг тийм газар юм гэсэн. Би мэдэхгүй юм. Эртний яриа байдаг штээ. Ямаан сахиустай байсан . Тэгээд ямаа майлж байдаг юм байх аа.

-Тэр дуганы нэр нь юу вэ?

Юу билээ?

-Дорлиг уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Тийм ээ үнэн.

-Дорлигийн чинь сэтэртэй мал нь ямаа байдаг штээ.

Тийм улаан ямаа байдаг.

- Тэгэхлээр ямаа майлна гэдэг чинь Дорлиг болж байна л даа.

Тэр хоёр далай бий. Бага далай, их далай гэж. Их далайнхаа баахан хойхнуур шиг нүүр байгаа. Хойд далайн зүүн хажууд дээр л байгаа.

-Тэр Хориотойн зүүн хажууд Үнэгтийн овооны хажууд дацан байсан гэж дуулсан үү?

Тэрийг мэдэхгүй. Над хүн хэлээгүй. Мэдэхгүй юм. Ийм газруудыг мэдэх юм. Дуулсан л энэ. Тухайн үед буриадууд Монгол орон гарч ирэхэд байгаагүй юм шүү дээ.

-Түрхэнэг гэж хаашаа юм?

Хориотойн зүүн хажуудах биш үү, бүү мэд бүү мэд. Би чинь их хол гараагүй. Мэдээ орсон цагаасаа хойш энд л байна.

-Дорлигийн дуган хэдэн дугантай байсан бол оо?

Тэрийг мэдэхгүй. Дорлиг дуган, Гуулинтын дуган гэж өвгөчүүл их хэлдэг байсан л даа. Хэдэн дугантай байсан, ямар хуралтай байсан тэрийг мэдэх юм юу ч байхгүй дээ. Юм мэдэхээр муу өвгөн дөө би.

-Та сая Дорлиг дуган, Гуулинтын дуган, Түрхэнэгийн дуган гурвыг хэлэв үү?

Аа тийм. Дорлиг дуган гэдэг чинь яриангүй Бага далайд байдаг. Харин Түрхэнэгийн дуган гэдэг чинь Хориотойн зүүн хажуудах биш үү, бүү мэд бүү мэд.

-Өөр мэдэх хүн байгаа юу?

Өөр мэдэх хүн байхгүй дээ. (Лувсанцэрэн гуай)